

“ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ” ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН

2023 он

ТАЙЛАН

Нэг. Ерөнхий зүйл

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай шинэчилсэн найруулгын төсөлд шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж, түүний үр нөлөөг тооцож, хуулийн төслийг боловсронгуй болгоход энэхүү үнэлгээний ажлын зорилго оршино.

Энэхүү үнэлгээг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийн зүйл, хэсэгт Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэв.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн шинэчлэн найруулсан төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-д заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

- 1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хоёр. Хуулийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, харилцан уялдаа зэрэг 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл буюу шалгуур үзүүлэлтүүд:

1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэллээ.

Тус үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

2.“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд нь тэдгээрийг дагаж мөрдөх болон хэрэгжүүлэх албан

тушаалтан, этгээдэд тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, нөхцөл байгаа эсэхийг үнэлэхээр сонгосон болно.

3.“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь хэрэглэх, хэрэгжүүлэхэд Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох аргачлалд заасан шаардлагыг хангасан, зөв томъёолсон эсэхийг үнэлэхээр сонгосон болно.

4.“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээ хийхээр тооцов.

Гурав. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг хангах эсэхийг судлах.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13 дугаар зүйл	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт нь бодит байдал дээр хэрэгжих боломжтой эсэхийг судлах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, холбогдох аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэх.
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагыг хангасан эсэх.

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсноор хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн зорилтыг төрийн цэргийн болон цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнээс энхийг дэмжих ажиллагаанд оролцох, түүнд хамаарах сургалт бэлтгэл, бусад арга хэмжээтэй холбогдсон харилцааг зохицуулахаар томъёолжээ.

Мөн Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэн цагдаагийн алба хаагч, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнд хамруулж, “цэрэг, цагдаагийн баг” гэсэн нэр томъёог шинээр нэмж, цэрэг, цагдаагийн багийн захирагч, цэрэг, цагдаагийн алба хаагч, багийн нийтлэг үүргийг нарийвчлан тусгана.

Түүнчлэн цэрэг, цагдаагийн багийг эгүүлэн татахтай холбогдох зохицуулалтуудыг өөрчлөн найруулж, зарим үг нэмж тусгана.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн зохицуулалтаар зөвхөн Зэвсэгт хүчний цэргийн багт Монгол Улсын Зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнээс энхийг дэмжих ажиллагаанд оролцох, түүнд хамаарах сургалт бэлтгэлтэй холбогдсон харилцааг

зохицуулсан бөгөөд Монгол Улсын цагдаагийн байгууллагаас энхийг сахиулах ажиллагаанд бие даан оролцуулах эрх зүйн зохицуулалт хязгаарлагдмал байсан.

Түүнчлэн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа болон олон улсын бусад ажиллагаа, хоёр талын хамтарсан хээрийн сургууль, дадлагад оролцох Монгол Улсын оролцооны цар хүрээ, оролцогчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдсэнтэй холбогдуулан энхийг сахиулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгон сайжруулах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Эдгээр эрх зүйн зохицуулалтууд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын мандаттай энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын бусад ажиллагаанд оролцох цэрэг, цагдаагийн байгууллагын эрх зүйн зохицуулалт тодорхой болж, Монгол Улсаас НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэх, алба хаагчийн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх чадавх дээшилнэ.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд цагдаагийн багийг оролцуулснаар Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлэхэд ахиц гарах, Монголын цагдаагийн байгууллага бусад улс орны цагдаагийн алба хаагчидтай хамтран ажилласнаар мэргэжлийн ур чадвар дээшлэх, харилцан туршлага солилцох, гадаадад үүрэг гүйцэтгэж буй өөрийн орны цэргийн багтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, ажиллагаанд ашиглаж буй зэвсэглэл, техникээс орж ирэх НҮБ-ын “нойтон” түрээсийн мөнгөн орлого улсын төсөвт орох зэрэг ач холбогдолтой юм.

3.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

№	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт
1	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх	Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: -энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоох; -Зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг бүрдүүлэхэд шаардлагатай зардлын төсвийг жил бүр батлах. Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: -Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн цэрэг, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах, эгүүлэн татах шийдвэр гаргах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцох асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, бүс нутгийн холбогдох байгууллага, бусад улстай гэрээ, хэлэлцээр байгуулах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын чадавхыг бүрдүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгуулах асуудлыг Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх; -цэрэг, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахтай холбогдсон

	нэмэлт санхүүжилт шаардлагатай тохиолдолд тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх; -энхийг дэмжих ажиллагааны сургалт, бэлтгэлийг өөрийн оронд зохион байгуулах, гадаад улсад энэ төрлийн арга хэмжээнд бие бүрэлдэхүүнийг оролцуулах шийдвэр гаргах; -Монгол Улсаас хилийн чанадад энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэлд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүн болон өөрийн оронд зохион байгуулах энэ төрлийн сургалт, бэлтгэлд оролцох гадаад орны бие бүрэлдэхүүн, тэдгээрийн зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгсэлд хил, гаалийн шалгалт хийх, навигацийн болон бусад үйлчилгээний журмыг тогтоох; -Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олгосон нөхөн төлбөрөөс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардал болон Зэвсэгт хүчин, Цагдаагийн хөгжлийн санд төвлөрүүлэх хувь хэмжээг тогтоох; -энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг санхүүжүүлэх журмыг тогтоох. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: -Монгол Улсаас оролцох боломжтой энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэл, тусламж, дэмжлэгийн асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран судалж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх; -Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаа, энэ талаархи сургалт, бэлтгэлд оролцуулах болон хангалт, үйлчилгээтэй холбогдсон асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, холбогдох улс, бүс нутгийн байгууллагатай харилцаж, зохицуулах; -энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэлд оролцож байгаа бие бүрэлдэхүүний эрхийг хамгаалах; -энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын гэрээгээр тогтоосон дүрэм, журам зөрчсөн, сахилгын ноцтой зөрчил гаргасан, амь насаа алдсан, шархадсан, ар гэрийн болон эрүүл мэндийн байдлаас шалтгаалан үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд эх оронд нь эгүүлэн татах ажлыг
--	---

	зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: -зэвсэгт хүчний цэргийн багийг энхийг дэмжих ажиллагаа болон сургалт бэлтгэлд оролцуулах асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх; -цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын сонгож санал болгосноор энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнийг томилох, хугацааг сунгах, эгүүлэн татах, ажиллагааны үүрэг гүйцэтгэлтийг дуусгавар болгох шийдвэр гаргах; -энэ хуулийн 8.1.4-т заасан шалтгааны улмаас бие бүрэлдэхүүнийг эгүүлэн татах ажлыг зохион байгуулах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх; -Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа байдлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газарт мэдээлэх; -энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг Зэвсэгт хүчний тухай хуульд заасны дагуу захиран зарцуулах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах, сургаж бэлтгэх, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журмыг батлах; -энэ хуулийн 8.1.4-т заасны дагуу эгүүлэн татах үед дараагийн цэргийн алба хаагчаар нөхөн хангах эсэх асуудлыг шийдвэрлэх; -энэ хуулийн 7.1.7-д заасан хувь хэмжээг тогтоох саналыг боловсруулж, Засгийн газраар шийдвэрлүүлэх; -энэ хуулийн 7.1.7-д заасны дагуу энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд томилолтын зардал олгох журмыг батлах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг батлах. Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: -цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаа болон сургалт бэлтгэлд оролцуулах асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран
--	---

	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх; -цагдаагийн төв байгууллагаас сонгож санал болгосноор энхийг дэмжих ажиллагаа, сургалт бэлтгэлд оролцуулах цагдаагийн алба хаагч, багийг томилох, сунгах, дуусгавар болгох шийдвэр гаргах; -энэ хуулийн 8.1.4-т заасан шалтгааны улмаас цагдаагийн алба хаагчийг эгүүлэн татах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг Цагдаагийн албаны тухай хуульд тухай хуульд заасны дагуу захиран зарцуулах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх; -энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах цагдаагийн баг, бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журмыг батлах. -энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг батлах. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: -энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагч, цэргийн багийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа цэргийн алба хаагч, цэргийн багийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих; -энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчтай гэрээ байгуулах, дүгнэх, түүний биелэлтэд хяналт тавих; -энхийг дэмжих ажиллагаанд шинээр оролцуулах цэргийн багийг Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх, бэлтгэлийг хангах, илгээх асуудлыг холбогдох байгууллагад уламжлах; -цагийн байдлын өөрчлөлтөөс шалтгаалан цэргийн алба хаагч, цэргийн багийн аюулгүй байдалд ноцтой аюул, заналхийлэл учирсан тохиолдолд тухайн ажиллагааны дээд штабтай харилцан ажиллаж, эрх бүхий албан тушаалтан, байгууллагыг мэдээллээр хангах, санал танилцуулах; -цэргийн алба хаагч, цэргийн багийн үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны цагийн байдлын талаар хагас жил тутам, шаардлагатай үед Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, Батлан хамгаалах асуудал
--	--

	эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тухай бүр мэдээлэх; -цэргийн алба хаагч, цэргийн багийн үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах саналыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах арга хэмжээг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар шийдвэрлүүлэх; -энхийг дэмжих ажиллагааны туршлага, сургамжийг судлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох. Цагдаагийн төв байгууллагын дарга холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: -цагдаагийн алба хаагч, багийн энхийг дэмжих ажиллагааны болон сонгон шалгаруулалтын өмнөх сургалт бэлтгэлийг зохион байгуулах; -цагдаагийн алба хаагч болон багийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих; -энхийг дэмжих ажиллагаанд шинээр оролцуулах цагдаагийн багийг Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх, бэлтгэлийг хангах, илгээх асуудлыг холбогдох байгууллагад уламжлах; -цагдаагийн алба хаагч болон багийн үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны цагийн байдлын талаар хагас жил тутам, шаардлагатай үед Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тухай бүр мэдээлэх; -цагдаагийн алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд нэр дэвшүүлэх, үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах, эгүүлэн татах асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр шийдвэрлүүлэх; -энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулах; -алба хаагчийг албан ажлын шаардлагаар өөртэй нь тохиролцсоны дагуу энхийг дэмжих ажиллагаанаас ирэх хүртэлх хугацаанд өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно. Тайлбар: албан ажлын шаардлагаар шилжүүлж байгаа бол тухайн албан хаагчид мэдэгдэж, саналыг бичгээр авсан байна. Цэрэг, цагдаагийн багийн захирагч нь тухайн багт нэгдмэл удирдлага, нэгтгэн захирах ёсыг хэрэгжүүлэгч, нийт бие бүрэлдэхүүний шууд захирах дарга бөгөөд дараах нийтлэг эрх,
--	--

	үүргийг хэрэгжүүлнэ: -сонгон шалгаруулалтад тэнцсэн бие бүрэлдэхүүний ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлийг удирдан явуулах; -цэрэг, цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, бие бялдар, ёс зүй, сахилга бат, нас, ажилласан жил, цол, ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлийн үр дүнг үндэслэн албан тушаалд томилох, чөлөөлөх санал гаргах; -Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн холбогдох тушаал, шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангах; -цэрэг, цагдаагийн багийн хэмжээнд цэргийн алба, цагдаагийн үйл ажиллагаа, сургалт бэлтгэл, бэлэн байдлыг хангах, үүрэг гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах, удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих; -бие бүрэлдэхүүний ажиллагааны үүрэг гүйцэтгэлт, сахилга хариуцлага, мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг харгалзан алба хаагчийг холбогдох албан тушаалд сэлгэн ажиллуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргах; -бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг удирдан зохион байгуулах; -энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байдал, үр дүнг үнэлж Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон бусад байгууллагын шагнал, Монгол Улсын төрийн одон, медаль, салбарын шагналаар алба хаагчийг шагнуулах саналыг холбогдох байгууллагад уламжлах; -энхийг дэмжих ажиллагаанд оролцсон туршлага, сургамжийн талаар санал, зөвлөмж боловсруулж, цэргийн мэргэжлийн дээд удирдлагын болон цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулах.
--	--

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. (Хуулийн төсөл 4 бүлэг, 16 зүйл).

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан хуулийн төсөл боловсруулахад тавигдах нийтлэг шаардлагыг тус тус хангасан гэж үзэв.

3.4. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн төслийн зүйл, заалтуудыг үзэхэд уялдаа, холбоог тодорхойлсон байна.

Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсээгүй байна.

№	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцсэн
2.	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм	Нийцсэн
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцсэн
4.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцсэн
5.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Давхардаагүй
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Тусгасан
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Орхигдуулаагүй
8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Давхардаагүй
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй	Тусгаагүй
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Тусгаагүй
11.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй	Тусгаагүй
12.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хязгаарлаагүй
13.	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Үгүй	Хөндөөгүй

14.	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Тусгаагүй
15.	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Тусгаагүй
16.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Тусгаагүй

Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-ын дагуу тооцож дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Үр нөлөөний үнэлгээг хуулийн төсөлд хийхэд сонгосон 4 шалгуур үзүүлэлтүүдээр хуулийн төслийн үзэл баримтлалд заасан зорилгыг хангасан, практикт хэрэгжих боломжтой, хуулийн төслийн томьёолол, зохицуулалт, найруулга нь ойлгомжтой, хоёрдмол утга санаа илэрхийлээгүй, Монгол Улсын үндсэн хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

Иймд холбогдох аргачлалд заасны дагуу Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, уялдаа холбоо хангагдсан гэж үзлээ.

Тус үр нөлөөг тооцох үнэлгээг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын хүрээнд хийв.

---oOo---